
**МЭДЭЭ** · 2022 оны 12-р сарын 27

# "ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ТӨВ"-ӨӨР ДАМЖУУЛАН ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА




Прокурорын байгууллага 2022 оны 12 дугаар сарын 19-нөөс 27-ны өдрүүдэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээд болон өмгөөлөгчөөс гаргасан 397 гомдол, хүсэлтийг шинээр хүлээн авч, нийт 1017 гомдол, хүсэлтийг хянан шалгав. Үүнээс 348-г нь шийдвэрлэж холбогдох арга хэмжээг авсан бөгөөд одоо прокурорт 669 гомдол, хүсэлт хянагдаж байна.

Шинээр хүлээн авсан гомдол, хүсэлтийн 10 нь ял эдлүүлэх ажиллагаатай холбоотой, 1 нь шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт шинээр илэрсэн нөхцөл байдлыг шалгуулах, 16 нь зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар  байгаа бол 321 нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар гаргасан гомдол, хүсэлт байна.

Дээрх хугацаанд Нийслэлийн Дүнжингарав, Мишээл төвүүдэд ажиллаж байгаа "Прокурорын байгууллагын нэг цонхны үйлчилгээ үзүүлэх төв"-д нийт 12 иргэний өргөдөл гомдлыг хүлээн авч харьяа прокурорын газарт нь шилжүүлж, 10 иргэнд прокурорын байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой зөвлөгөө мэдээллийг өгч ажиллав.

Видео: https://www.youtube.com/watch?v=_wraPhGsDzY

---

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2071